

7. Хөрш улстай хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Түүнчлэн Монгол Улсын эрүүгийн болон захиргааны хариуцлагын тухай хуулиудад хилийн аюулгүй байдлыг хангах талаар тэр бүр бүрэн хэмжээгээр тусгаагүй учир тэдгээрт зохих хэмжээгээр нэмэлт оруулах шаардлага ч байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр дамжааны сонсогч,
дэд хурандаа В.Пүрэвбаасан*

ХИЛИЙН БООМТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хүн төрөлхтөний үүсэл, хөгжлийн бүх үе шатад хувь хүн, нийгэм, улс орон, хамтын нийгэмлэгийн амьдрал үйл ажиллагааны салшгүй дагуул нь аюул занал байсаар ирсэн. Аюулгүй байдлын асуудалд төдийлөн анхаарал тавьж байгаагүйгээс өрх гэр, компани, улс орон бутран сөнөж, дайн самуун дэгдэж гай гамшиг тарьж байв.

Аюул нь аюулгүй байдлын объектыг устгах, тонон дээрэмдэх, хүлцэнгүй захирагдах байдалд оруулах, дарамтлан дээрэмдэх, устгахад чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөх, бэлтгэх, уг үйлдлийг гүйцэтгэхийг санаархах зэрэг янз бүрийн хэлбэрээр илэрдэг байна.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй асуудлын нэг бөгөөд түүнийг хөрш зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллага хооронд хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулдаг онцлогтой.

Дэлхий нийтэд өрнөж байгаа даяаршил, нийгэм, улс төрийн байдал, манай орны гадаад дотоод бодлого нь улсын хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын асуудалд шинжлэх ухааны үүднээс хандахын чухлыг харуулж байна.

Орчин үеийн дэлхий ертөнцөд гарч буй томоохон өөрчлөлтүүд, хил дамнасан гэмт хэрэг, нийгэм эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитойгоор нөлөөлөх болов.

Улсын хил зөрчих, зэвсгийн наймаа, алан хядах ажиллагаа, мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг хүрээгээ тэлж байгаа нь түүнтэй тэмцэх хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга хэлбэрээр өөрчлөн сайжруулахыг шаардаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад Хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол өсөн нэмэгдсээр байна. 2001 онд УИХ-аар батлагдсан "Үндэсний аюулгүй байдлын тухай" Монгол Улсын хуулийн хоёрдугаар бүлгийн 6 дугаар зүйлд "Үндэсний аюулгүй байдлын тогтолцоо нь Монгол Улсын УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнуудаас бүрдэнэ"; мөн "Монгол Улсын хилийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд "... үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах" гэж тус тус тодорхойлсон байна.

Энэ бүхэн Монгол Улсын хил хамгаалах байгууллагын төрийн захиргааны байгууллага болон гүйцэтгэх үүргийн онцлогоор Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд багтаж аюулгүй байдлыг хангах хэрэгт оролцон тодорхой үүрэг, хариуцлага хүлээх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байхыг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог.

Мөн хилийн аюулгүй байдал гэдэг нь "улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал" гэж манай эрдэмтэд үздэг билээ.

Монгол Улсын хил хамгаалах байгууллага, хилчдийн үндсэн үүрэг нь улсын хилийн баталгаажилт, хамгаалалтын найдвартай байдлыг ямарч нөхцөлд хангах явдал юм. 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гэсэн гуравдугаар бүлэгт: оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал" юм гэжээ.

Эндээс "Хилийн боомтын аюулгүй байдал"-ын асуудал нь **нэгдүгээрт**: "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна¹" гэсэн Үндсэн хуулийн заалт, дээрх үзэл баримтлалын дагуу "Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдал"-д.

¹Монгол Улсын Үндсэн хууль. Цахим эх сурвалж: www.legalinfo.mn

хоёрдугаарт: “Хил зөрчигч, завдагчийг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл, тээвэрлэж байгаа бараанд үзлэг хийх, манаагаар дагалдуулах, Улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, бараанд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр 1эвтрүүлэхийг хориглосон, хязгаарласан эд зүйлсийг хураан авч холбогдох байгууллагад мэдэгдэх, хамтран шийдвэрлэх¹” гэж Хил хамгаалалтын дүрэмд зааснаар улсын эдийн засгийн аюулгүй байдалтай шууд холбогдож байна.

Улсын хил нь өөрөө агуулгын хувьд хоёр улс, нэг хил гэсэн утгаараа аливаа хөрш улсууд зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн найрсаг харилцаа тогтоож, дэлхийн улсуудтай олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримтлахыг шаарддаг ба манай улс болон дэлхийн улс орнууд ч энэ харилцааг эрхэмлэдэг.

Манай улс хөрш орнууд болон бусад олон улсуудтай олон талт харилцааг хөгжүүлж буй өнөөгийн нөхцөлд дэлхийн эдийн засгийн хурдацтай хөгжил, гадаадаас улсын хил, хязгаар нутаг дахь хилийн асуудлыг зохион байгуулж буй өөрчлөлт, дотоодоос хилийн бүс, зурваст хувийн өмчит аж ахуйн нэгжийн ажил, үйлдвэрлэл явуулах ажиллагаа ихэсч, улсын хилийн боомтоор түүхий эд, бараа материал тээвэрлэх, иргэдийн зорчих хөдөлгөөн хурдацтай өсөн нэмэгдэж, энэ нь улс орны эдийн засгийн үзүүлэлтэд шууд нөлөөлж байгаа зэрэг нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, түүний нэн чухал хэсэг болох хилийн аюулгүй байдал, тэр тусмаа хилийн боомтын аюулгүй байдалд нөлөөлөх болсон.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэн хилийн боомтыг хөгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх зорилгоор “Хилийн боомтын тухай” хуулийг УИХ-аас 2013 оны 12 дугаар сарын 26-нд батласан ба энэ хуулиар хилийн боомтын удирдлагын бүтцийг өөрчлөн, “боомтын хяналтын байгууллага болон боомтын аюулгүй байдлыг хангах байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, ерөнхий зохицуулалтаар хангах үүрэг бүхий Боомтын нэгдсэн захиргааг байгуулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд ажиллахаар болсон. Уг хуульд “боомт” гэж зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх зориулалттай, тусгай журмаар зохицуулагддаг нутаг дэвсгэрийг, “боомтын аюулгүй байдлыг хангах байгууллага” гэж боомтын аюулгүй байдлыг хангах, боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэх хил хамгаалах, тагнуулын байгууллагыг² хэлнэ гэж тодорхойлжээ.

¹ Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм.

² Хилийн боомтын тухай хууль. Цахим эх сурвалж: www.legalinfo.mn

Хил хамгаалах байгууллага шинээр батлагдсан дээрх хуулийн дагуу хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмыг сахиулж байна.

Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь “Улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах” ХХЕГ-ын даргын удирдамж, хилийн тусгай ангийн захирагчийн болон хилийн тусгай салбарын даргын тушаал зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд захирамжлагдан, хэрэгжиж байна.

Хилийн боомтын тухай хуульд “Боомтод нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах, террорист халдлага гарах, гоц халдварт өвчин тархах зэрэг онцгой нөхцөл үүссэн үед боомтыг хил хамгаалах байгууллага хамгаалалтад авч, холбогдох байгууллагатай хамтран тусгай дэглэм тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулна¹” гэж заасны дагуу ХХБ-аас хилийн боомтын аюулгүй байдлыг хангах талаар хөрш орнууд, харилцан ажиллагаатай байгууллагууд, орон нутгийн ард иргэдтэй харилцан, хуульд заасан дээрх нөхцөл үүссэн үед ажиллах урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөнүүдийг шинэчлэн боловсруулах ажиллагаа явагдаж байна. Өнөөгийн байдлаар энэ хуулийн дагуу хил хамгаалах байгууллагын мэргэжлийн хэлтэс, хилийн отрядуудын албан тушаалтнуудын нэр, бүтэц, чиг үүрэгт өөрчлөлт орсон. Мөн боомтын аюулгүй байдлыг хангах албан тушаалтнууд дутмаг, тээврийн хэрэгслийг шалгах цаг хугацаа зэргээс хамаарч тээврийн хэрэгсэлд хийх үзлэг шалгалт хангалтгүй явагдаж, улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлдэг бүлэг, этгээдүүдийн үйл ажиллагаа ихсэх хандлагатай байна гэж дүгнэж болохоор байна. Хилийн боомтын албаны чиглэлээр 2014 онд зонхилон гарсан зөрчлийг авч үзвэл:

- Хилийн тагнуулын албанаас 2014 оны 04 дүгээр сараас хойш бусдын баримт бичиг ашиглах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, бусдын нэр, регистрийн дугаарыг ашиглан гадаад паспорт, Монгол Улсад буцах үнэмлэх гаргуулах хэлбэрээр Буянт-Ухаа, Замын-Үүд, Алтанбулаг. Цагааннуур боомтуудаар улсын хил зөрчсөн 68 хүнд хойшлуулшгүй ажиллагаа явуулсан.

- ИХШХБ-ын алба хаагчдаас ажлын хариуцлага алдаж, хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичгээр улсын хил нэвтрүүлж буцаагдсан 3, хилийн уулзалтаар хүлээн авсан 37 зөрчлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

- Хилийн боомтын журамд хяналт тавих манааны хяналтаар хилийн боомтын хяналтын байгууллага болох Гааль, Мэргэжлийн хяналтын алба, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний байгууллагуудын шалгалтаар ороогүй хил нэвтрэхийг завдсан 224 иргэнийг илрүүлж гарч болзошгүй

¹ Хилийн боомтын тухай хууль.

зөрчлөөс урьдчилан сэргийлсэн.

- Хилийн 0218 дугаар анги болон "Чингис хаан" олон улсын нисэх буудлын хамгаалалтын алба хооронд боомтын аюулгүй байдлыг хангах асуудалтай холбоотойгоор үүссэн үл ойлголцол даамжирч Засгийн газрын хэмжээнд хүрсэн бөгөөд уг асуудлыг ЗГХЭГ-ын дарга, ЗТЯ-ны сайд нар хамтран "Чингис хаан олон улсын агаарын замын боотмод аюулгүй байдлыг хангах, боомтын журам сахиулах, хамтран ажиллах журам" баталснаар шийдвэрлэгдсэн.

- Буянт-Ухаа. Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги, Бичигт, Булган, Хавирга, Алтанбулаг, Сүхбаатар, Цагааннуур боомтуудаар улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан эд зүйлс болох алт, байгалийн үнэт чулуу, төмрийн хүдэр, зэс, ноолуур, ургамал, ан амьтны мах, арьс, эвэр, бурхан шашны эд зүйл, хар тамхи, сэргээшийн төрлийн бэлдмэл, бууны сум болон гаалийн татвараас зайлсхийсэн эд зүйлсийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан зөрчлүүдийг илрүүлэн шийдвэрлэсэн байна. Дээрх байдлаас дараах цагийн байдал үүсэж болзошгүй байна. Үүнд:

1. Улсын хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичигтэйгээр улсын хил нэвтрэх, нэвтрэхийг завдах үйлдэл үргэлжлэн гарч, түүнийг ИХШХБ-ын шалгагч нарын хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаалан илрүүлэхгүй хил нэвтрүүлэх;

2. Ачаа, тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, шалгалт суларсантай холбогдуулан улсын хил нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан эд зүйл, тээврийн хэрэгсэлд нууж хил нэвтрүүлэх зэрэг зөрчил грч болзошгүй.

3. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалалын тухайд авч үзвэл Монгол-Оросын иргэд харилцан визгүй зорчих тухай 2014 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Монгол Улс, ОХУ-ын иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр" 11 дүгээр сарын 14-нөөс хэрэгжиж эхэлсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 46 дугаар тогтоолоор 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс "Алтанбулаг" боомт 24 цагийн ажиллагаанд шилжсэн ба мөн уг тогтоолоор "Хавирга", "Баянхошуу". "Ханги"\' "Бургастай" боомтыг байнгын ажиллагаанд шилжиж мөн Өмнөговь аймгийн Хүрмэн сумын нутаг дэвсгэрт "Цагаан дэл" байнгын ажиллагаатай авто замын боомтыг шинээр нээх болсноор хилийн боомтуудын ачаалал нэмэгдэх хандлагатай байна.

4. Өмнөд хилийн "Гашуунсухайт", "Шивээхүрэн", "Бичигт", "Сүмбэр" боомтуудад төмөр замын боомт шинээр байгуулагдахтай

холбоотойгоор албаны ачаалал нэмэгдэж, хүн хүч, техник хэрэгслийн нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

5. Хилийн боомтоор хүн, мал, ургамлын гаралтай гоц халдварт өвчин орж ирэх асуудлууд үүсч болзошгүй байна.

Иймд хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зохимжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Дээрх цагийн байдал, өөрчлөлтүүдийг тухай бүр нь судлан дүн шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээ, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;

2. ХБАБ-ын хангахад шаардагдах хүн хүчний тооцоог боомт тус бүрийн онцлогт тохируулан хийж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх, тэдгээрт шаардагдах техник хэрэгслээр хангах;

3. Хөрш улсын талтай хилийн төлөөлөгчийн шугамаар тогтмол хамтран ажиллаж, мэдээ, мэдээллийг шуурхай солилцох, тэдний ХБАБ-ыг хангаж буй байдлыг судлан, тагнуул гүйцэтгэх ажлын хүчийг түлхүү ашиглах;

4. Хилийн боомтын аюулгүй байдал хангах албаны урьдчилсан ажилллагааны төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх, шаардлагатай бол тодотгол хийх;

5. Боомтын аюулгүй байдлын албанд ажиллагсдыг тусгай зориулалтын хувцас, аюулгүй байдлыг хангах тусгай хэрэгсэл, албаны нохойг хангах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх;

6. Үндэстэн дамнасан корпорациуд, гэмт бүлэглэлийн эсрэг тэмцэх ажиллагаанд тагнуул, цагдаа, гаалийн байгууллагуудтай хамтран ажиллах нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

7. Харилцан ажиллагааны төлөвлөгөөний дагуу сургалт, дадлагыг тогтмол явуулах;

8. Гааль, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран тээврийн хэрэгсэлд хийх үзлэг, хяналт шалгалтыг цаг хугацаанд нь чанартай явуулах зэрэг арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Энэ бүгд нөхцөл байдлаас дүгнэхэд хил хамгаалах байгууллага одоогоор хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ба цаашид хуулиар хүлээсэн үүргээ чанаржуулах, үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөхийн тулд боомтод үүрэг гүйцэтгэж буй хилчдийнхээ мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, холбогдох хуулийн дагуу уйгагүй идэвхтэй ажилласнаар үйл ажиллагаагаа төр засгийн хэмжээнд бодитойгоор үнэлүүлж зохих амжилтад хүрэх боломжтой гэж үзэж байна.